

# **АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГЫН САЛБАРЫН 2016 ОНЫ ТАНИЛЦУУЛГА**



# ТАНИЛЦУУЛГЫН ХУРААНГУЙ

## Нэг. Оршил

- 1.1. Судалгаа шинжилгээний ажлын тухай ойлголт
- 1.2. Судалгаа шинжилгээний ажилд тавигдах шаардлага, гүйцэтгэх дэс дараалал
- 1.3. Судалгааны зорилго
- 1.4. Онол арга зүй

## Хоёр. Аж үйлдвэрийн

- 2.1. Нийтлэг үндэслэл
- 2.2. Ойлголт тодорхойлолт
  - 2.3.1. Мэдээллийн эх үүсвэр
  - 2.3.2. Хамрах хүрээ ангилал
  - 2.3.3. Баянхонгор аймгийн барилга, аж үйлдвэрийн салбаруудын өнөөгийн байдал

## Гурав. Дүгнэлт

## Оршил хэсэг

### Судалгаа шинжилгээний ажлын тухай ойлголт

**Судалгаа шинжилгээний ажил** гэдэг нь янз бүрийн хүчин зүйл /фактор/-ээс хамааран судалж буй зүйл /объект/-ийн өөрчлөгдөх шинэ үзэгдэл зүй тогтлыг илрүүлж тэрхүү зүй тогтлыг цаашид амьдрал практикт ашиглаж болох зорилго бүхий үйл ажиллагаа юм.

Судалгаа шинжилгээний ажил нь тавьсан зорилт түүнийг шийдвэрлэх арга үр дүнг хэрэглэх салбараас хамаарч онолын, онол туршилтын, туршилтын , суурь, хавсралт, тухайн, иж бүрэн гэж ангилагдана.

### Судалгаа шинжилгээний ажилд тавигдах шаардлага, гүйцэтгэх дэс дараалал

Аливаа судалгаа шинжилгээний ажил нь тодорхой зорилго, төлөвлөгөө, иүе шаттай явагдана. Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ дараах дэс дарааллыг баримтлана. Үүнд:

- Судалгаа шинжилгээний ажлын сэдвийг сонгож зорилгоо тогтоох
- Судлах гэж байгаа зүйлийнхээ одоогийн байдлыг судалж зохих дүгнэлт өгсөн байх
- Энэ дүгнэлт дээрээ үндэслээд уг объектын хувьд чухам юуг ялган авч судлах гэж байгаа зорилтоо тодорхойлох
- Судалгааны аргачлал боловсруулах
- Судалгаа явуулах
- Судалгааны үр дүнг боловсруулж дүн шинжилгээ хийх
- Судалгааны үр дүнгээр дүгнэлт, зөвлөмж гаргах
- Судалгааны үр дүнг бичлэгийн /курс, дипломын төсөл, тайлан, диссертаци гм\* хэлбэрт юмуу зураг төсөл, бусад хэлбэрт оруулах

### Судалгааны зорилго

Аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлэхэд нооц боломжийг хэрхэн ашиглах, улс, бүс нутгийн түвшинд эзэлж буй байр суурь , цаашдын чиг хандлагыг тодорхойлоход гол зорилго оршино.

Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар нь Баянхонгор аймгийн голлох салбар мөн юм.

### Онол арга зүй

Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, борлуулалт, үндсэн

хөрөнгө болон санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж, аж ахуйн нэгжийн сар, жилийн тайлан, тооллого судалгааны үр дүнгийн тоон мэдээллийг ашиглан тэдгээрийг нэгтгэн гаргадаг.

**Үйлдвэрлэл нь** тухайн аж ахуйн нэгжийн зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Борлуулалт нь** Тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээг бүтээгдэхүүний борлуулалтыг хэлнэ.

Цахилгаан станц, нүүрсний уурхайн мэдээг үндэслэн цахилгаан, дулаан эрчим хүч, нүүрсний тэнцлийг жилд нэг удаа нэгтгэн гаргадаг.

Үйлдвэрлэсэн, импортлосон цахилгаан эрчим хүч, нүүрсний хэмжээ, цахилгаан станцын дотоод хэрэглээ, түгээлтийн болон шугамын алдагдал, хувиарлалтыг эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбараар ангилж, зөвхөн биет хэмжээгээр тэнцэлд тусгаж байна.

### **Аж үйлдвэрийн индекс тооцох аргачлал**

#### **Нийтлэг үндэслэл**

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн хэмжээнд бүтээгдэхүүний биет хэмжээ, үнэ гэсэн 2 хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөллийг арилгаж, зөвхөн үйлдвэрлэлийн өсөлтийг тодорхойлох зорилгоор статистикийн практикт үйлдэрлэлийн индексийн ашигладаг.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индекс нь эдийн засгийн үйл ажиллагаан дахь богино хугацааны өөрчлөлт, эдийн засгийн хөгжлийг харуулах нэг шалгуур үзүүлэлт болдог. Сонгогдсон бүтээгдэхүүний тоо хэмжээ, бүлэг, дэд салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээнд эзлэх хувийн жин болон тодорхой салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн индексийг үндэслэн аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийг тооцдог.

Энэхүү аргачлалыг аж үйлдвэрийн үйлдвэрлэгчийн үнийн индекс тооцоход мөрдлөг болгодог, Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийг “**Үйлдвэрлэгчийн үнийн индекс тооцох аргачлал**”-ын дагуу тооцдог.

#### **Ойлголт, тодорхойлолт**

Энэхүү аргачлалд орсон нэр томъёог дараах байдлаар ойлгож хэрэглэнэ.

**Бүтээгдэхүүн** гэж бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлтэд завсрын хэрэлээний орц хэлбэрээр, эсвэл хүн амын жцсийн хэрэглээ болж ашиглагдах зорилгоор үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон биет зүйлийг

**Нийт үйлдвэрлэлт** гэж ААНБ, иргэдийн өөр нэг байгууллагын хэрэглээнд болон эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт хэмжээг

**Индекс** гэж тухайн үзэгдлийн тодорхой хугацааны өөрчлөлтийг харуулсан харьцангуй хэмжигдэхүүнийг

**Үйлдвэрлэлийн индекс** гэж бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгасан, зөвхөн биет хэмжээний өөрчлөлтийг илэрхийлэх үзүүлэлтийг

**Үйлдэрлэлийн үнийн индекс** гэж ААНБ-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн /үйлдвэрлэгчийн үнээрх/ өөрчлөлтийг илэрхийлэх үзүүлэлтийг

**Үйлдвэрлэгчийн үнэ** гэж аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ явуулахад гарсан зардал, ашигийг батаасан үйлдвэрийн газрын үнийг

**Жин** гэж Индексийг тооцоход тухайн цаг хугацаанд өөрчлөлтгүй хэвээрээ байх хэмжигдэхүүнийг, тухайлбал тодорхой төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн нийт үйлдвэрлэлтэд эсвэл түүний орлогын нийт орлогод эзлэх хувь хэмжээг

**Дефляторын арга** гэж үнэ болон биет хэмжээний элементээс бүрдэх хувьсагчаас биет хэмжээний / тоо хэмжээ болон чанар / элементийг ялгаж тодорхойлох аргыг

**Суурь үе** гэж үзэгдлийн өөрчлөлтийг судлах зорилгоор сонгож авсан тулгуур үеийг

**Тайлант үе** гэж өнөөгийн үйл ажиллааны үр дүнг харуулсан тодорхой хугацааг хлнэ . Тайлант үе нь сар, улирал, жил байна.

**Хувийн индекс** гэж нийлмэл юмс үзэгдлийн зөвхөн нэ бүрэлдэхүүн хэсийн өөрчлөлтийг харуулсан индексийг хэлнэ. Аж үйлдвэрийн дэд салбарын хувьд хувийн индекс нь, тухайлбал уул уурхай олборлох салбарын нүүрс олборлолтын дэд салбарын индекс, бусад ашигт малтмал олборлолтын дэд салбар зэрэг салбарын индекс байна.

**Ерөнхий индекс** гэж бүх бүрэлдэхүүн хэсээс тогтох нийлмэл үзэгдлийн бүх элементийн дундаж брчлблтийг харуулсан индексийг хэлнэ. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн ерөнхий индекс нь салбаруудын индексийн тэдгээрийн суурь үеийн нийт үйлдвэрлэлийн дүнд эзлэх хувийн жингээр жигнэж тооцсон индекс байна.

#### **Мэдээллийн эх үүсвэр**

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индекс тооцоход аж үйлдвэрийн бүтээгдэхүүний биет хэмжээ, үйлдвэрлэчийн үнээс гадна индексийн тооцоонд

ашиглах жинг тодорхойлох зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнтэй уялдаж мэдээллийн эх үүсвэрийг дараах байдлаар бүрдүүлнэ. Үүнд:


- Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний биет хэмжээг нэгтгэн гаргах мэдээллийн эх үүсвэр нь “ **Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн сарын мэдээ** “ / АҮ-1 / байна.
- Индексийн тооцоонд ашиглах жинг тооцох мэдээллийн эх үүсвэр нь
  - Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын дүн
  - Бизнес регистрийн сангийн холбогдох үзүүлэлт, аж үйлдвэрийн салбарын жилийн эцсийн мэдээ / ААНБ1, ААНБ2 / байна.

## АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### **Нийт үйлдвэрлэлт:**

2016 онд аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 5487064.6 мянган төгрөг болж өмнөх оныхоос 10.4 хувиар буюу 515971.6 мянган тогроогоор өссөн байна.

### **Бүтээгдэхүүн борлуулалт мян.төг**



Нийт үйлдвэрлэлтийн өсөлт бууралтыг салбараар нь авч үзвэл уул уурхайн олборлох салбар, хувцас үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар, сүү цагаан идээний үйлдвэрлэлт, дулаан үйлдвэрлэл өсч, харин нийтлэх, хэвлэх үйл ажиллагааны салбар, усан хангамжийн үйлдвэрлэлийн салбар, модон эдлэл үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт буурсан судалгаа гарлаа.

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт өссөн шалтгаан нь шинээр аж ахуй нэгжүүд байгуулагдан тодорхой хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэн үйл ажиллагаа явуулж байгаа явдал юм.

### **Талх, нарийн боов үйлдвэрлэлт:**

Аймгийн хүн амын хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүн нь талх нарийн боов юм. Аймагт талх нарийн боовны үйлдвэрлэл нилээдгүй их бий.

Талх нарийн боов үйлдвэрлэдэг томоохон аж ахуй нэгжүүд гэвэл

аймгийн төвд Их тэнгэрийн хүч ХХК, Сүлдэн тэнгэр хоршоо, Түвшин хороот ХХК, сумдад Их халбагант ХХК, Бай Баян-Өндөр, Номин хөх хоршоо, Дулаан цэнхэр, Доуций, Таван эрдэнэ тахилгат хайрхан зэрэг ХХК-иуд юм.

2013 онд 69.0 тн, 2014 онд 82.5 тн, 2015 онд 113.4 тн талх үйлдвэрлэсэн бол 2016 онд 201.3 тн талх үйлдвэрлэж 2015 оноос 87.9 тонноор буюу 77.5 хувиар өссөн үзүүлэлт гарлаа. 2013 оноос хойшхи үйлдвэрлэлтийг харахад жил бүр талх үйлдвэрлэлт өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цаашид ч мөн өсөх магадлалтай харагдаж байна.




Нарийн боов үйлдвэрлэлт 2013 онд 74.4 тн 2014 онд 60.5 тн, 2015 онд 80.2 тн нарийн боов үйлдвэрлэж байсан бол 2016 онд 162.3 тн нарийн боов үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин буюу 82.1 тонноор өссөн байна. Нарийн боов үйлдвэрлэлтийн дийлэнх хувийг Сүлдэн тэнгэр хоршоо үйлдвэрлэсэн байна.

2016 оны үйлдвэрлэлт 2015 оны үйлдвэрлэлтээс хэт өссөн шалтгааныг олон янзаар тайлбарлаж болох юм. Жишээ нь:

1. Иргэдийн өдөр тутмын хэрэглээ учир зайлшгүй худалдан авдаг.
2. Хэрэглэгчид Улаанбаатар хотын үйлдвэрийн бүтээгдэхүүн авахаас илүү аймгийн үйлдвэрлэдэг гурилан бүтээгдэхүүнийг ихээхэн худалдан авдаг болсон.

3. Сумдад талх, нарийн боов үйлдвэрлэдэг ААН, цех, иргэд нэмэгдсэн нь энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөд нөлөөлсөн.




### **Нүүрс олборлолт:**

Нүүрс олборлолт 2013 онд 31.1 мянган тонн, 2014 онд 40.8 мянган тонн, 2015 онд 43 мянган тонн байсан бол 2016 онд 49.6 мянган тонн болж өмнөх оноос 15.3 хувиар буюу 6.6 мянган тонноор өссөн байна. Нүүрс олборлолтын үйл ажиллагааг Баялаг Орд ХХК Галуут сумын нутаг дэвсгэрт явуулж байна. Баялаг Орд ХХК-ийн олборлож буй нүүрс илч сайтай, хямд үнэтэй тул олборлолт урьд онуудаасаа эрс нэмэгдэн аймгийн нүүрсний хэрэглээг бүхэлд нь ханган ажиллаж байна. Баялаг Орд ХХК нь жил бүр машин техник технологийг бүрэн шинэчлэн ажиллаж байгаа нь олборлолт нэмэгдэх бас нэг шалтгаан болсон байна.

Мөн Баялаг Орд ХХК нь чанартай, илч сайтай нүүрс олборлодог болохоор иргэдийн сэтгэлд нийцэж оор аймгийн нүүрсийг хэрэглэх нь эрс багассан.

Манай аймагт сүүлийн жилүүдэд барилгын салбар хурдацтай хөгжиж байгаа бөгөөд тэдгээрийн халаатад ихээхэн хэмжээний нүүрс хэрэглэж байгаа нь Баялаг Орд ХХК-ний нүүрс олборлолт өсөхөд нөлөөлж байх талтай.



#### **Дулаан үйлдвэрлэлт:**

Дулаан үйлдвэрлэл нь эдийн засаг, нийгмийн салбаруудын үйл ажиллагааг хангагч суурь салбар бөгөөд бусад бараа, бүтээгдэхүүний нэг адил нооцолж хадгалдаггүйгээрээ онцлог юм.

2013 онд 193.6 мян.Гкал, 2014 онд 207.7 мян.Гкал, 2015 онд 192.0 мян.Гкал дулаан үйлдвэрлэсэн бол 2016 онд 242.2 мян.Гкал дулаан үйлдвэрлэж өмнөх оныхоос 26.1 хувиар өссөн байна.

Сүүлийн жилүүдэд барилгын салбар хурдацтай хөгжиж байгаа болохоор дулаан үйлдвэрлэл өсөхөд нөлөөлж байна.

## БАЯНХОНГОР АЙМГИЙН БАРИЛГА, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэмжээнд 2016 онд нийт 30 гаруй аж ахуй нэгж байгууллага 9.4 орчим тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт баригдсан орон сууцны барилгыг төрлөөр нь авч үзвэл угсармал, тоосгон, блокон хийцтэйгээр баригдсан байна. Нийт баригдсан орон сууц болон эрчим хүч, зам, шугам шүлжээ, сургууль соёл, үйлчилгээний барилга байгууламж болон их засварын ажлуудыг Баянхонгор аймгийн барилгын аж ахуйн нэгжүүд хийж гүйцэтгэсэн.

Барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдийг гүйцэтгэлээр нь авч үзвэл Чандмань-Баянхонгор ХК, РМБ- ХХК, Хаш гоёо ХХК, Эх бүрдэн ХХК, Гал хонгор ХХК-ууд хамгийн өндөр гүйцэтгэлтэй байгаа бол Их Богд зам ХК нь автозамын засварын ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

2010 оноос жил бүр барилгын салбарын бүтээн байгуулал нэмэгдэж байна.

Манай аймгийн хувьд дэд бүтэц сайн хөгжсөн аймгуудын нэг бөгөөд орон сууцны барилгын тоо сүүлийн жилүүдэд хурдастай хөгжиж байна. Боловсролын салбарт түүн дотроо цэцэрлэг сургуулиудын их засварын ажлуудад төр засгаас анхаарч байгаа нь ихээхэн түлхэц нөлөө үзүүлж байна.

Зах зээлийн хөгжлийн эхэн үед барилгын салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон байсан. Барилгын томоохон үйлдвэр, аж ахуйн газрууд хувьд шилжсэн. Материаллаг бааз нь хувьчлагдан задарсан өөрөөр хэлбэл эмх замбараагүй байдалд орсны улмаас барилгын салбар уналтад орсон. Улс, орон нутгийн төсвөөр барилга барих үйл ажиллагаа багассан. Тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгох болсонтой холбоотойгоор орон нутагт барилгын үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүд тендерийн шаардлага хангахгүй оролцож чадахгүйд хүрч байсан.

Харин 2010 оноос барилгын үйл ажиллагаа нэмэгдэж орон нутгийн барилгын чиглэлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн бодлого

баримталснаар зарим барилга угсралт, их засварын ажлыг аймгийн аж ахуйн нэгжүүд хийснээр аймгийн барилгын салбарын үйл ажиллагаа сэргэж эхэлсэн.

### **Барилга угсралтын ажлын гүйцэтгэл барилгын төрлөөр**

<b>МД</b>	<b>Барилгын төрөл</b>	<b>2016 Улирал-4 Тайлант оны гүйцэтгэл (өссөн дүнгээр)</b>
3	Орон сууцны барилга, гарааштай	980 000.0
12	Худалдаа, үйлчилгээний	1 490 000.0
14	Эмнэлэг	1 702 700.0
16	Цэцэрлэг	1 750 753.0
18	Соёлын	206 404.0
20	Конторын	1 815 000.0
21	Орон сууцны бус бусад барилга	170 600.0
34	Хатуу хучилттай авто зам	873 814.0
41	Бусад (бусад зам, талбайн ажил)	292 576.0
52	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	122 000.0
		<b>9 403 847.0</b>

## **Дүгнэлт**

Аймгийн хэмжээгээр аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтыг 2016 оны байдлаар авч үзвэл нийт үйлдвэрлэлт, борлуулалтын 90.6 хувийг хувийн 38 аж ахуйн нэгж, 4.8 хувийг улсын үйлдвэрийн газрууд, 4.6 хувийг хувийн ахуйн үйлчилгээ эзэлж байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалтын хэмжээ жил бүр өссөн байна.

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт борлуулалт хэвийн хэмжээнд явагдаж аймгийн хэрэгцээг ханган ажиллаж байна гэж дүгнэж болохоор харагдаж байна.

Сүү цагаан идээ үйлдвэрлэлтийн хувьд Баянлиг сумын Их халбагант ХХК үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сумын иргэдийг тогтмол шинэ талх, нарийн боов, савалгаатай цагаан идээгээр ханган ажиллаж байна.

Нүүрс олборлолтыг аймгийн хэмжээнд Баялаг орд ХХК дангаараа гүйцэтгэж байна. Тус компани сүүлийн хэдэн жилд техник технологийн шинэчлэлт байнга хийж ажилласнаар нүүрс олборлолтыг нэмэгдүүлж чадсан байна. Олборлож буй нүүрс нь илчлэг сайтай, хямд үнэтэй тул иргэдийн сэтгэлд нийцэн бусад газраас нүүрс худалдан авдаг байсныг бууруулж нутгийн олборлолтыг дэмжин ажиллаж байна.

2013-2016 онуудад зарим нэр торлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч байгаа ч шинээр аж ахуй нэгж байгуулагдан шинэ нэр торлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж байгаа нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт осоход ноололсон байна.

Манай аймгийн хувьд дэд бүтэц сайн хөгжсөн аймгуудын нэг бөгөөд орон сууцны барилгын тоо сүүлийн жилүүдэд хурдастай хөгжиж байна. Боловсролын салбарт түүн дотроо цэцэрлэг сургуулиудын их засварын ажлуудад төр засгаас анхаарч байгаа нь ихээхэн түлхэц нөлөө үзүүлж байна.

## **ҮЗҮҮЛЭЛТИЙН ХАМРАХ ХУГАЦАА**

2013-2016 оны үеийн хугацаан дахь сүүлийн 4 жилийг хамруулав.

### **Хавсралт**

1. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт 2013 -2016 оноор
2. Гол нэр торлийн бүтээгдэхүүн 2013-2016 оноор

### **Ашигласан материал**

1. Аймгийн эдийн засаг нийгмийн байдлын танилцуулга 2013-2016 он
2. Монгол улсын статистикийн эмхэтгэлүүд 2013, 2014, 2015 он